



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/490

Булган сум

Г Гадаадын зочин төлөөлөгч хүлээн авах зардал гаргах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын 104 жилийн ойн аймгийн баяр наадамд хүрэлцэн ирэх гадаадын зочин төлөөлөгч хүлээн авахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 12,080,500 (арван хоёр сая наян мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 08 -ны/ний өдрийн
А. (190) дугаар захирамжийн хавсралт

Гадаадын зочин төлөөлөгч хүлээн авахад
шаардагдах зардлын төсөв

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1	2	3	4	5
1.Шатахууны зардал				
1	Угтаж, үдэх шатахуун Булган-Эрдэнэт-Булган	1 машин, 140 км	28л*2750	77,000
2	Зочдын машинд хийх шатахуун	3 машин, 600 км	120л*2750*3 машин	990,000
3	Ажлын хэсгийн машины шатахуун	3 машин, 200 км	90л*2750	247,500
Нийт 1,314,500 төг				
2.Байр, хоолны зардал				
4	Зочид буудал, 13 хүн /Буриадын төлөөлөгчид/	5 өрөө*3хон	194,000	2,910,000
5	Зочид буудал, 2 хүн /Дархан хотод суугаа ОХУ-ын Дэд консул, жолооч/	2 өрөө*1хон	190,000	380,000
6	Өдрийн хоол	21 хүн	32,000	672,000
7	Оройн хоол	24 хүн	32,500	780,000
8	Хүлээн авалт	21 хүн	82,000	1,722,000
9	Хүлээн авалт, зочид буудлын өрөөний хүнс			2,024,000
10	Малчин айлд зочлох			700,000
11	Зочдыг угтах			400,000
Нийт 9,588,000 төг				
3. Бэлэг дурсгал				
12	Гарын бэлэг	19 ш	62,000	1,178,000
Нийт 1,178,000 төг				
НИЙТ 12,080,500 төг				